



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 32 болон 33 дахь долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 08-р сарын 09-ны байдлаар

Энэхүү танилцуулгад гадаад орчинд гарч буй өөрчлөлт, түүхий эдийн үнийн товч мэдээлэл бэлтгэлээ.


1 ГАДААД ОРЧНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт

Гадаад орчны төлөв оны эхэнд хийсэн төсөөллөөс тасралтгүй муудаж байгаа бөгөөд цаашид ч энэ байдал үргэлжлэх төвийг олон улсын байгууллагууд илэрхийлж байна¹. Тухайлбал, 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл энэ оны эхэнд 4.4 хувь байсан

бол шинэчлэгдэх бүрд муудсаар 8-р сард хийсэн төсөөллөөр 3.0 хувь болж буураад байна. Үүнд АНУ, БНХАУ, Евро бүс, ОХУ зэрэг глобал эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч томоохон улсуудын эдийн засгийн өсөлт буурсан нь том нөлөөтэй байна (Зураг 1).

Зураг 1. Гадаад эдийн засгийн өсөлтийн төсөөлөл 2022-2023 он, хугацаагаар



Эх сурвалж: Блумберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн өсөлтийн хувьд олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

¹ ОУВС, Дэлхийн банк, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Рубини, Экономист мэдээллийн төв зэрэг томоохон

судалгааны байгууллагууд цаашид дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллөө муутгах хүлээлттэй байна.



Томоохон судалгааны байгууллагууд 1) ОХУ-Украины мөргөлдөөн, 2) өндөр савлагаатай байгаа түүхий эдийн үнэ, 3) хүнс, эрчим хүчний үнийн огцом өсөлт, 4) БНХАУ-ын эдийн засгийн өсөлт хүлээгдэж байснаас илүү эрчтэй саарсан, 5) улс орнуудын хэрэгжүүлж буй мөнгөний бодлогоо хатууруулах чиглэлд хурдтай өөрчилж байгаа зэрэг олон хүчин зүйлс нийлээд дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулах чиглэлд хөтөлж байгааг онцлов.

Тодруулбал:


- ХНБ-наас хүүгийн түвшнээ энэ онд 3.00-3.25% хүртэл нэмэгдүүлэх төлөвтэй бөгөөд энэ нь бодит цалингийн өсөлт сөрөг байгаа өнөөгийн нөхцөлд 2023 оноос АНУ-д эдийн засгийн хямрал дагуулж болзошгүй юм.
- БНХАУ-ын эдийн засгийн хувьд Тэг-КОВИД бодлого 2023 онд мөн үргэлжлэх төлөвтэй байгааг судлаачид дурджээ. БНХАУ-ын улсын төсвөөс үзүүлэх дэмжлэг өмнө хүлээгдэж байснаас бага нөлөөтэй байх тул энэ оны өсөлт 4 хувиас давж гарахааргүй байна. БНХАУ-аас КОВИД-19 цар тахлын хүрээнд баримталж буй тааварлашгүй, гэнэтийн бодлогын шийдвэрүүд 2022 оны туршид ажиглагдаж, улмаар олон

улсад тодорхой бус байдлыг үүсгэнэ гэж үзсэн байна.

- Үүний зэрэгцээ түүхий эдийн үнэ огцом өсөж, эрчим хүчний зах зээлийн нийлүүлэлт доголдож байгаагаас гадна хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийн өсөлт дэлхий даяар хүнсний аюулгүй байдал, нэн ядуурлыг улам даамжруулахад нөлөөлж байна.

Инфляц

Инфляцын төсөөлөл оны эхнээс хойш нэмэгдэж дэлхий даяар инфляцын түвшин сүүлийн хэдэн 10 жилд байгаагүй дээд утгад хүрч байна. Цар тахлын дараа дэлхийн эдийн засагт нийлүүлэлтийн сүлжээний доголдлоос улбаатай эрэлт нийлүүлэлтийн зөрүү үүсэж, үүнээс шалтгаалж түүхий эдийн үнэ огцом нэмэгдсэн, Орос-Украины хоорондын асуудлаас шалтгаалж эрчим хүч, хүнс, голлох металлын үнэ огцом өссөн зэргээс инфляцын түвшин ийнхүү өндөр түвшинд хүрээд байна. Тухайлбал, 2022 оны 6-р сарын байдлаар инфляц АНУ-д 9.1 хувь, Евро бүсэд 8.6 хувь, ОХУ-д 15.9 хувьд тус тус хүрчээ. Дэлхийн инфляцын түвшин 2023 оноос эргэн буурах ч олон орны хувьд инфляцын зорилтот түвшнээс өндөр түвшинд хадгалагдах хүлээлттэй.

Зураг 2. Инфляцын төсөөлөл 2022-2023 оны сүүлийн улирлаар, хугацаагаар

Эх сурвалж: Блумберг, Рубини, EIU, ОУВС, Дэлхийн өсөлтийн хувьд олон улсын байгууллагуудын төсөөллийн дундаж

2

ТҮҮХИЙН ЭДИЙН ҮНИЙН ТӨЛӨВ

Зэс: Зэсийн хамгийн том хэрэглэгч болох БНХАУ цар тахлаас сэргийлэх зорилгоор томоохон аж үйлдвэрийн хотуудад хөл хорио тогтоосноор тус улсын аж үйлдвэрийн салбарын борлуулалтын менежерийн индекс сүүлийн саруудад агшиж, зэсийн эрэлт буурлаа. Нэг тонн зэсийн үнэ 2022 оны 6 дугаар сард дунджаар 9,024 ам.доллар байсан бол 7 дугаар сард 7,525 ам.доллар болж унаад байна. Нийлүүлэлт талаас Чили улсад усны хомсдол, Австрали улсад ажиллах хүчний хомсдол үүссэн хэдий ч зэсийн эрэлт нийлүүлэлтээ давж буурчээ. Зэсийн үнэ дунджаар 2022 онд 9282 ам.доллар/тонн, 2023 онд 9142.3 ам.доллар/тоннд хүрэх хүлээлттэй байна.

Алт: Нийлүүлэлтийн сүлжээний доголдол үргэлжилж дэлхийн улс орнуудын инфляц өндөр түвшинд, ОХУ-Украинтай холбоотой геополитикийн эрсдэл өндөр байгаа нь алтны үнэ өндөр

байхад нөлөөлж байна. Нэг унц алтны үнэ 2022 оны 6 дугаар сард дунджаар 1,837 ам.доллар, 7 дугаар сард дунджаар 1,736 ам.доллар байна. Ийнхүү алтны үнэ 2022 онд 1846 ам.доллар/унц, 2023 онд 1776 ам.доллар/унцад хүрэх тооцоололтой байна.

Коксжих нүүрс: Нэг тонн коксжих нүүрсний үнэ 2022 оны 6, 7 дугаар саруудад дунджаар харгалзан 350 ам.доллар, 249 ам.доллар байв. Нүүрсний үнэд оны эхээр 1) ОХУ-д тавьсан хориг арга хэмжээнээс шалтгаалж ОХУ-ын экспортолдог эрчим хүчний голлох бүтээгдэхүүнүүд болох газрын тос, нүүрс, байгалийн хийн нийлүүлэлт буурсан, 2) “Тэг-ковид” бодлогын улмаас БНХАУ-ын дотоодын нүүрсний үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаар ажиллаагүй нь өсөх нөлөөг үзүүлж байсан. Харин 2-р улирлын турш гангийн үйлдвэрүүдийн ашгийн маржин буурч, улмаар гангийн үнэ



буурах хандлагатай байсан нь коксжих нүүрсний үнийг сааруулах нөлөө үзүүллээ. Цаашид нүүрсний үнийн төлөв ОХУ-Украины нөхцөл байдал хэрхэн өрнөх, БНХАУ-ын Засгийн газраас цар тахлын эсрэг хэрэгжүүлэх бодлогоос ихээхэн хамаарахаар байна.


Төмрийн хүдэр: Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 2022 оны 6, 7 дугаар саруудад дунджаар 122 ам.доллар, 99 ам.долларт тус тус хүрлээ. Төмрийн хүдрийн томоохон нийлүүлэгч болох Австрали улсад ажиллах хүчний хомсдол үүсээд байгаа, Бразил улсад оны эхэн үед үер болсон нь нийлүүлэлтийг бууруулсан. Гэвч эрэлт талаас БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн захын нөхцөл байдал улам хүндэрч, баригдаж дуусаагүй царцсан барилгын төслүүдийн худалдан авагчид нэгдэж, цахим сүлжээгээр ипотекийн зээлээ төлөхөөс татгалзах тэмцлийг орон даяар өрнүүлж эхэлсэн нь төмрийн хүдрийн үнийн төлөвт сөргөөр нөлөөлж байна. Шинжээчдийн төсөөллийн дунджаар төмрийн хүдрийн үнэ дунджаар 2022 онд 120.5 ам.доллар/тоннд, 2023 онд

97.1 ам.доллар/тоннд байх төлөвтэй байна.

Газрын тос: Нэг баррель брент маркийн газрын тосны үнэ 2022 оны 7 дугаар сард 105 ам.доллар байж өндөр түвшинд хадгалагдав. Эрэлт талаас 1) дэлхий даяар эдийн засаг үргэлжлэн сэргэсэн, 2) газрын тосны нөөц бага түвшинд хүрсэн, 3) байгалийн хийн үнэ өсөж газрын тосоор байгалийн хийг орлуулах болсон нь нөлөөллөө. Нийлүүлэлт талаас 1) ОПЕК+ нэгдэл үйлдвэрлэлийн төлөвлөгөөндөө хүрээгүй, 2) Казахстан, Ливи зэрэг орнууд газрын тос олборлох талбайдаа засвар хийх шаардлагатай болсон, 3) Нигери улсын олборлож буй газрын тос замаасаа хулгайлагдаж байгаа зэрэг нь газрын тосны үнэ хадгалагдахад нөлөөлж байна. Брент маркийн газрын тосны үнэ Блүүмбергийн шинжээчдийн төсөөллийн дунджаар 2022 онд 106.7 ам.доллар/баррель, 2023 онд 92.9 ам.доллар/баррель болж нэмэгдлээ. Газрын тосны үнийн цаашдын төлөв ОХУ-Украины нөхцөл байдал, ОПЕК+ нэгдэл төлөвлөгөөндөө хүрэх эсэхээс голлон хамаарахаар байна.



Зураг 3. Түүхий эдийн зах зээл дээрх голлох бүтээгдэхүүний үнийн төлөв



Эх сурвалж: Блумберг, Рубини, EIU, BREE, ОУВС, Дэлхийн банкны төсөөллийн дундаж



Ашигласан материалууд:

<https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2022/07/26/world-economic-outlook-update-july-2022>

<https://www.worldbank.org/en/publication/global-economic-prospects>

<https://continuumeconomics.com/2022/06/17/outlook-overview/outlook-overview-inflation-risks-food-for-tho-1>

<https://continuumeconomics.com/2022/06/20/outlook/outlook-forecasts-to-download-in-excel-13>

<https://store.eiu.com/Article.aspx?issueid=1652307548>

<https://store.eiu.com/Article.aspx?issueid=812264264>

<https://store.eiu.com/Article.aspx?issueid=492283232>

<https://www.industry.gov.au/data-and-publications/resources-and-energy-quarterly-june-2022>